



ЗАМ, ГҮҮРИЙН ЗУРАГ ТӨСӨЛ
ИНЖЕНЕР-ТЕХНОЛОГИЙН ЗӨВЛӨХ
“ГЕО ЗУРАГЛАЛ” ХХК

ТАЙЛБАР БИЧИГ

БАРУУН-УРТ СУМЫН 7-Р БАГ "БОЛОВСРОЛ", "УРГАХ НАРАН",
"ЭКО" ХОРООЛЛУУДЫН ДУНДАХ АВТО ЗАМЫН
НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ



УЛААНБААТАР ХОТ
2021он



ЗАМ, ГҮҮРИЙН ЗУРАГ ТӨСӨЛ
ИНЖЕНЕР-ТЕХНОЛОГИЙН ЗӨВЛӨХ
“ГЕО ЗУРАГЛАЛ” ХХК

ТАЙЛБАР БИЧИГ

БАНУУН-УРТ СУМЫН 7-Р БАГ "БОЛОВСРОЛ", "УРГАХ НАРАН",
"ЭКО" ХОРООЛЛУУДЫН ДУНДАХ АВТО ЗАМЫН
НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ



Дэд захирал
Ерөнхий инженер



Ж.БАТНАСАН
Г.НАМУУН



УЛААНБААТАР
2021 он

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ.....	3
1.1 Зураг төсөл боловсруулах үндэслэл.....	3
1.2 Зураг төслийн иж бүрдэл	4
1.3 Төсөл хэрэгжих газрын тухай.....	4-5
1.4 Авто зам сайжруулах зайлшгүй шаардлага.....	6
1.5 Тухайн авто замуудын орчны одоогийн байдал.....	6-13
2. ЗАМЫН ШИНЖ ЧАНАР	14
2.1. Зам, цаг уур амьсгал	14-16
2.2. Авто замын байр зүйн судалгаа.....	17-18
2.3 Инженер геологийн судалгаа.....	19
3. АВТО ЗАМЫН ТӨЛӨВЛӨЛТ	20
3.1. Төлөвлөлтийн стандарт шалгуур үзүүлэлт.....	20-22
3.2. Дагуу ба хөндлөн төлөвлөлт	23-32
3.3 Инженерийн шугам сүлжээ.....	23
3.4 Асфальтбетон хучилт.....	33
3.5 Байгалын чулуун хучилт /10см*10см*10см/	33
3.6 Хучилтын тооцоо.....	34-40
3.7 Явган хүний замын хийц.....	41-44
3.8 Айлууд руу орох орц, гарц төлөвлөлт.....	44-48
3.9 Авто замын тохижилт, тоноглол.....	Error!

Bookmark not defined.



Хавсралтууд

- Авто замын тэнхлэгийн координатууд
- Ажлын тоо хэмжээ
- Зургийн даалгавар
- Батлагдсан трассын байршиллын тойм
- Цахилгааны техникийн нөхцөл
- "Дөрвөлж ОНӨН" ХХК дулааны техникийн нөхцөл
- Холбооны техникийн нөхцөл

1. ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 7-р баг "Боловсрол", "Ургах наран", "Эко" хорооллуудын дундах авто замын нарийвчилсан зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээг 2021 онд “ГЕО ЗУРАГЛАЛ” ХХК-д гүйцэтгэв.

1.1 Үндэслэл

- Сүхбаатар аймгийн засаг даргын баталсан АЗЗ/2021/03 дугаартай зураг төсөл боловсруулах ажлын даалгавар
- Аймгийн засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.1.4.2, аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөний 6.1.11
- “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” БНБД 30-01-04
- “Авто зам төсөллөх” ЗЗБНБД 22-04-2016
- “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлага” ЗЗБНБД 31-008-2016
- Явган хүний зам, талбайн төлөвлөлт. техникийн шаардлага MNS 6808:2019
- “Талын хөрс” ХХК –ний боловсруулсан инженер –геологийн хайгуул судалгааны ажлын тайлан.
- “Инженер геодези” ХХК –ний боловсруулсан байр зүйн зураглалын ажлын тайлан.

1.2 Зураг төслийн иж бүрдэл

- Авто замын ажлын зураг
- Холбооны шугамын ажлын зураг
- Цахилгаан, гэрэлтүүлгийн шугамын ажлын зураг
- Авто замын зурвасын инженер – геологийн хайгуул судалгааны ажлын тайлан
- Авто замын зурвасын байр зүйн зураглалын ажлын тайлан
- Авто замын барилгын ажилд тавигдах техникийн шаардлага
- Авто замын ажлын зургийн тайлбар бичиг
- Авто зам, холбоо, цахилгаан, гэрэлтүүлгийн барилгын ажлын хяналтын төсөв


1.3 Авто зам сайжруулах зайлшгүй шаардлага

Энэхүү авто замуудыг шинээр барьснаар аймгийн төвийн авто замын сүлжээг өргөтгөх, нийтийн эзэмшил, хорооллын зам талбайг тохижуулж, оршин суугч иргэдийн амьдрах, ая тухтай байдалыг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

1.4 Төсөл хэрэгжих газрын тухай

Уг төсөл Сүхбаатар аймгийн Баруун-Урт сум 7-р баг "Боловсрол", "Ургах наран", "Эко" хорооллуудын нутаг дэвсгэрт хэрэгжих бөгөөд Улаанбаатар хотоос 560км зайд оршино.

Зураг 1. Баруун-Урт сумын 7-р баг "Боловсрол", "Ургах наран", "Эко" хорооллуудад баригдах 3 хэсэг авто замуудын байршлын тойм зураг.



1.5 Тухайн авто замуудын орчны одоогийн байдал

Төслийн авто замуудыг байрлалаас нь хамааран 3 хэсэг болгон хуваан зураг төсвийг хийж гүйцэтгэлээ. Авто замын трассыг ажлын даалгаварын дагуу төлөвлөсөн бөгөөд бусад холбогдох байгууллагуудтай зөвшилцсөний үндсэн дээр төлөвлөлөө.

1-р хэсэг. Боловсрол хорооллын авто зам







Зураг 2. Баруун-Урт сумын 7-р баг "Боловсрол" хороололд Баригдах Таван хэсэг авто замын байршлын тойм зураг.

1-р зам 0.461км

Трассын эхлэл нь нисэхийн ард талын хатуу хучилттай авто замаас эхлэн одоо баригдаж буй цэцэрлэг хүртэл 0.461км үргэлжлэн 3-р замтай огтлолцож төгсөнө. Төлөвлөж буй авто зам нь 6м өргөнтэй, замын 2 талаар 0.5м ногоон байгууламж, 1.5м явган замтай, 8 уулзвар, 7 гарцтай байхаар төлөвлөлөө.

Хүснэгт 1. Авто замын трассын орчны байдал

	
<p>Трассын эхлэл /Км 0+000/ Уулзвар №1 Одоо байгаа авто замтай огтлолцох хэсэг</p>	<p>Трассын эхлэл /Км 0+000/ Уулзвар №1 Одоо байгаа авто замтай огтлолцох хэсэг</p>
	
<p>Км 0+060 Ус цаг уурын бетон хашаатай хэсэгт ногоон байгууламжгүй 1.5м явган замтай байхаар төлөвлөсөн.</p>	<p>Км 0+160 Айлын төмөр хашаа гудамж руу орох орц, гарцыг хааж байгаа тул шилжүүлэхээр төлөвлөсөн.</p>



Км 0+200 5.1-р замтай огтлолцох хэсэг



Км 0+300 Одоо байгаа хайрган хучилттай зам



Трассын төгсгөл Км 0+461.05 Уулзвар №8



Трассын төгсгөл Км 0+461.05 3-р замтай огтлолцох хэсэг

1. 2-р зам 0.456км

Трассын эхлэл нь нисэхийн ард талын хатуу хучилттай авто замаас эхлэн одоо баригдаж буй сургууль хүртэл 0.456км үргэлжлэн 3-р замтай огтлолцож төгсөнө. Төлөвлөж буй авто зам нь 6м өргөнтэй, замын 2 талаар 0.5м ногоон байгууламж, 1.5м явган замтай, 8 уулзвар, 7 гарцтай байхаар төлөвлөлөө.

Хүснэгт 2. Авто замын трассын орчны байдал



Трассын эхлэл /Км 0+000/ Уулзвар №1 Одоо байгаа авто замтай огтлолцох хэсэг



Км 0+026 Трасс орж буй овоолсон шороо



Км 0+026 Трасс орж буй овоолсон шороог зайлуулахаар төлөвлөсөн.



Км 0+126 Трасс орж буй цамхагт гэрлийг зөөж шилжүүлэхээр төлөвлөсөн.



Км 0+114 Трасс орж буй байшингийн суурийг зайлуулахаар төлөвлөсөн.



Км 0+260 4-р замтай огтлолцох хэсэг



Км 0+320 Одоо байгаа дулаан шугамыг баруун талын ногоон байгууламж доогуур орохоор төлөвлөсөн.



Км 0+400 Дэлгүүрийн төмөр хашаа, тоглоомын талбайг шилжүүлэхээр төлөвлөсөн.



*Трассын төгсгөл Км 0+455.74
Уулзвар №8*



*Трассын төгсгөл Км 0+455.74
3-р замтай огтлолцох хэсэг*

2. 3-р зам 0.351км

Трассын эхлэл нь одоо байгаа хатуу хучилттай авто замаас эхлэн баригдаж буй цэцэрлэг, сургуулийн урдуур 0.351км үргэлжлэн одоо байгаа хатуу хучилттай авто замтай огтлолцож төгсөнө. Төлөвлөж буй авто зам нь 6м өргөнтэй, замын 2 талаар 0.5м ногоон байгууламж, 1.5м явган замтай, 6 уулзвартай байхаар төлөвлөлөө.


Хүснэгт 3. Авто замын трассын орчны байдал



*Трассын эхлэл /Км 0+000/ Уулзвар №1
Одоо байгаа авто замтай огтлолцох
хэсэг*



*Км 0+000 Трасс орж буй явган замын
хавтан, төмөр хашааг зайлуулахаар
төлөвлөсөн.*



*Км 0+227 – Км 0+325 хүртэлх трасс орсон
дулаан шугамыг урагш нь 6м шилжүүлэхээр
төлөвлөсөн.*



*Трассын төгсгөл Км 0+351.10
Одоо байгаа авто замтай огтлолцох хэсэг*

3. 4-р зам 0.427км

4-р зам нь 3 хэсгээс бүрдэх бөгөөд 4.1-р зам 0.152км, 4.2-р зам 0.085км, 4.3-р зам 0.190км урттай. Трассын эхлэл нь одоо байгаа хатуу хучилттай авто замаас эхлэн хороолол дундуур 1 болон 2-р замыг хөндлөн гарч 0.427км үргэлжлэн одоо байгаа хатуу хучилттай авто замтай огтлолцож төгсөнө. Төлөвлөж буй авто зам нь 6м өргөнтэй, замын 2 талаар 0.5м ногоон байгууламж, 1.5м явган замтай, 4 уулзвар, 13 гарцтай байхаар төлөвлөлөө.



Хүснэгт 4. Авто замын трассын орчны байдал



4.1-р зам трассын эхлэл /Км 0+000/
Уулзвар №1 Одоо байгаа авто замтай
огтлолцох хэсэг




Км 0+000 Трасс орж буй явган замын
хавтан, төмөр хашаа, ногоон
байгууламжийг зайлуулахаар
төлөвлөсөн.



4.1-р замын Км 0+080 айлуудруу орох орц
гарцыг айл болгон руу төлөвлөж өгсөн.



4-р зам 1-р замтай огтлолцох хэсэг
Уулзвар №2



4.2-замын трасс Км 0+000 – Км 0+085.44



4.2-зам 2-р замтай огтлолцох хэсэг



Уулзвар №2



4.3-зам Трассын төгсгөл Км 0+189.30



4.3-зам Трасст орж буй явган замын хавтан, төмөр хашаа, ногоон байгууламжийг зайлуулахаар төлөвлөсөн.

4. 5-р зам 0.367км

5-р зам нь 2 хэсгээс бүрдэх бөгөөд 5.1-р зам 0.157км, 5.2-р зам 0.210км урттай. 5.1-р нь одоо байгаа хатуу хучилттай авто замаас эхлэн 1-р замын уулзвар хүртэл 0.157км үргэлжлэн төгсөнө. 5.2-р зам нь 2-р замын уулзвараас эхлэн 0.210км үргэлжлэн одоо байгаа хатуу хучилттай авто замтай холбогдож төгсөнө. Төлөвлөж буй авто зам нь 6м өргөнтэй, замын 2 талаар 0.5м ногоон байгууламж, 1.5м явган замтай, 4 уулзвар, 15 гарцтай байхаар төлөвлөлөө.

Хүснэгт 5. Авто замын трассын орчны байдал



5.1-р зам трассын эхлэл /Км 0+000/
Уулзвар №1 Одоо байгаа авто замтай
огтлолцох хэсэг



5.1-р зам трассын төгсгөл /Км 0+157.05/
1-р замын уулзвар хүрэн төгсөнө.




5.2-р зам трассын эхлэл /Км 0+000/ Уулзвар №1 2-р замын уулзвараас эхлэнэ.



5.2-р зам трассын төгсгөл /Км 0+210.32/ Одоо байгаа замтай огтлолцож төгсөнө.

2-р хэсэг. Ургах наран хорооллын авто зам



Зураг 3. Баруун-Урт сумын 7-р баг "Ургах наран" хороололд баригдах Гурван хэсэг авто замын байршлын тойм зураг.

1. 1-р зам 0.098км

Трассын эхлэл нь нэг давхар барилгын зүүн талаас эхлэн 0.098км үргэлжлэн 3-р замтай огтлолцож төгсөнө. Төлөвлөж буй авто зам нь 6м өргөнтэй, замын 2 талаар 1.5м явган замтай, 2 уулзвар, 4 гарцтай байхаар төлөвлөлөө.

Хүснэгт 6. Авто замын трассын орчны байдал



Трассын эхлэл /Км 0+000/



Одоо байгаа авто замын хашлага, явган замын хавтанг хуулж зайлуулахаар төлөвлөсөн. /Км 0+020/



Трассын төгсгөл Км 0+097.74 3-р замтай огтлолцох хэсэг



Трассын төгсгөл Км 0+097.74 Явган замд орж буй цэвэр, бохир усны шугамын худгийг өндөрлөж хүчитгэхээр төлөвлөсөн.

2. 2-р зам 0.205км

Трассын эхлэл нь 3-р замын уулзвараас эхлэн зүүн тийш 0.205км үргэлжлэн одоо байгаа хатуу хучилттай авто замтай огтлолцож төгсөнө. Төлөвлөж буй авто зам нь 6м өргөнтэй, замын 2 талаар 1.5м явган замтай, 2 уулзвар, 10 гарцтай байхаар төлөвлөлөө.

Хүснэгт 7. Авто замын трассын орчны байдал



Трассын эхлэл /Км 0+000/



Одоо байгаа авто замын хашлага, явган замын хавтанг хуулж шинээр хийхээр төлөвлөсөн. /Км 0+020/



Км 0+140 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын урд талаар гарах хэсэг




Трассын төгсгөл Км 0+204.79 Одоо байгаа замтай уулзаж төгсөнө.

3. 3-р зам 0.122км

Трассын эхлэл нь одоо байгаа хатуу хучилттай авто замаас эхлэн 2 давхар байшин хүртэл 0.122км үргэлжлэн төгсөнө. Төлөвлөж буй авто зам нь 6м өргөнтэй, замын 2 талаар 1.5м явган замтай, 2 уулзвар, 5 гарцтай байхаар төлөвлөлөө.

Хүснэгт 8. Авто замын трассын орчны байдал



Трассын эхлэл /Км 0+000/
Одоо байгаа хатуу хучилттай авто замаас эхлэнэ.



Трассын төгсгөл /Км 0+122.54/
2 давхар байшингийн өмнө төгсөнө.

3-р хэсэг. Эко хорооллын авто зам




Зураг 4. Баруун-Урт сумын 7-р баг "Эко" хороололд баригдах Арван хэсэг авто замын байршлын тойм зураг.

1. 1-р зам 0.565км

Трассын эхлэл нь 10-р замын уулзвараас эхлэн 0.565км үргэлжлэн одоо байгаа хатуу хучилттай авто замтай огтлолцож төгсөнө. Төлөвлөж буй авто зам нь 6м өргөнтэй, замын 2 талаар 0.5 ногоон байгууламж, 1.5м явган замтай, 10 уулзвартай байхаар төлөвлөлөө.

Хүснэгт 9. Авто замын трассын орчны байдал



2. 2,3,4,5,6s,7,8,9,10-р зам 2.573км

Трассын эхлэл нь одоо байгаа хатуу хучилттай авто замаас эхлэн 1-р замыг хөндлөн гарч хатуу хучилттай авто замтай огтлолцон төгсөнө. Төлөвлөж буй авто замууд нь 6м өргөнтэй, замын 1 талаар 0.5 ногоон байгууламж, 1.5м явган замтай, шаардлагатай газруудад уулзвар, гарц орцыг төлөвлөлөө.

Хүснэгт 10. Авто замын трассын орчны байдал



4.1-р замын трассын эхлэл
/Км 0+000/



5.1-р замын трассын эхлэл
/Км 0+000/



7.1-р замын трассын эхлэл
/Км 0+000/



8.2-р замын трасс /Км 0+040/
Дулааны шугам шинээр хийгдсэн хэсэг



4.2-р замын трассын төгсгөл
/Км 0+201.80/



7.2, 8.2-р замын трассын төгсгөл
хэсэгт ган хоолой төлөвлөн одоо
байгаа шуудууг бетон бэхлэгээтэй
хийхээр төлөвлөвөө.



1.6 Төслийн техникийн үзүүлэлтүүд

1-р хэсэг. Боловсрол хорооллын авто зам – 2.062км

Хүснэгт 11.

№	Үзүүлэлтүүд	нэгж	1-р зам	2-р зам	3-р зам	4.1, 4.2, 4.3-р зам	5.1, 5.2-р зам	
1	Замын зэрэг	-	Нутаг дэвсгэрийн туслах гудамж зам					
2	Замын урт	км	0.461	0.456	0.351	0.427	0.367	
3	Тойруугийн тоо	ш	3	3	0	0	0	
4	Тойруугийн хамгийн бага радиус	м	1200	400	-	-	-	
5	Тойруугийн хамгийн их радиус	м	1200	1200	-	-	-	
6	Тойруугийн нийт урт	м	108.98	84.43	-	-	-	
7	Тойруугийн трассд эзлэх хувь	%	23.95	18.56	-	-	-	
8	Босоо гүдгэр муруйн хамгийн бага радиус	м	2500	1918	2271	1235	3408	
9	Босоо гүдгэр муруйн хамгийн их радиус	м	6667	3240	4634	2906	5509	
10	Босоо хотгор муруйн хамгийн бага радиус	м	2143	2225	4167	1224	-	
11	Босоо хотгор муруйн хамгийн их радиус	м	5764	3809	7500	1628	-	
12	Дагуугийн хамгийн их налуу	%	1.8	2.4	2	3.2	2.53	
13	Дагуугийн хамгийн их налууугийн үргэлжлэх урт	м	15	8	24	15.5	60.3	
14	Замын далангийн өргөн	м	12.68	12.68	12.68	12.68	12.68	
15	Зорчих хэсгийн өргөн	м	6	6	6	6	6	
16	Хөвөөний өргөн	м	0.5x2	0.5x2	0.5x2	0.5x2	0.5x2	
17	Явган хүний замын өргөн	м	1.5x2	1.5x2	1.5x2	1.5x2	1.5x2	
18	Тооцоот хурд	км/цаг	30	30	30	30	30	
19	Өндөрлөгөөний хажуу налуу	m:n	1:1.5	1:1.5	1:1.5	1:1.5	1:1.5	
20	Ухмалын хажуу налуу	m:n	1:1.5	1:1.5	1:1.5	1:1.5	1:1.5	
21	Хучлагын хийц	-	Жижиг ширхэгтэй өнгө асфальтбетон – 3см Том ширхэгтэй суурь асфальтбетон – 4см Буталсан чулуун суурь – 20см Суурийн доод үе – 30см					



2-р хэсэг. Ургах наран хорооллын авто зам – 0.425км

Хүснэгт 12.

№	Үзүүлэлтүүд	нэгж	1-р зам	2-р зам	3-р зам
1	Замын зэрэг	-	Нутаг дэвсгэрийн туслах гудамж зам		
2	Замын урт	км	0.098	0.205	0.122
3	Тойруугийн тоо	ш	0	1	0
4	Тойруугийн хамгийн бага радиус	м	50	-	-
5	Тойруугийн хамгийн их радиус	м	50	-	-
6	Тойруугийн нийт урт	м	28.78	-	-
7	Тойруугийн трассд эзлэх хувь	%	29.4	-	-
8	Босоо гүдгэр муруйн хамгийн бага радиус	м	2084	2990	2036
9	Босоо гүдгэр муруйн хамгийн их радиус	м	2084	2990	2036
10	Босоо хотгор муруйн хамгийн бага радиус	м	-	1871	-
11	Босоо хотгор муруйн хамгийн их радиус	м	-	1871	-
12	Дагуугийн хамгийн их налуу	%	2.5	1.74	1.87
13	Дагуугийн хамгийн их налууугийн үргэлжлэх урт	м	20	12.5	81.1
14	Замын далангийн өргөн	м	10.52	10.52	10.52
15	Зорчих хэсгийн өргөн	м	6	6	6
16	Хөвөөний өргөн	м	0.5x2	0.5x2	0.5x2
17	Явган хүний замын өргөн	м	1.5x2	1.5x2	1.5x2
18	Тооцоот хурд	км/цаг	30	30	30
19	Өндөрлөгөөний хажуу налуу	m:n	1:1.5	1:1.5	1:1.5
20	Ухмалын хажуу налуу	m:n	1:1.5	1:1.5	1:1.5
21	Хучлагын хийц	-	Жижиг ширхэгтэй өнгө асфальтбетон – 3см Том ширхэгтэй суурь асфальтбетон – 4см Буталсан чулуун суурь – 20см Суурийн доод үе – 30см		

3-р хэсэг. Эко хорооллын авто зам – 3.138км
Хүснэгт 13.

№	Үзүүлэлтүүд	нэгж	Нийт 10 хэсэг авто зам
1	Замын зэрэг	-	Нутаг дэвсгэрийн туслах гудамж зам
2	Замын урт	км	3.138
3	Тойруугийн тоо	ш	0
4	Тойруугийн хамгийн бага радиус	м	-
5	Тойруугийн хамгийн их радиус	м	-
6	Тойруугийн нийт урт	м	-
7	Тойруугийн трассд эзлэх хувь	%	-
8	Босоо гүдгэр муруйн хамгийн бага радиус	м	813
9	Босоо гүдгэр муруйн хамгийн их радиус	м	15000
10	Босоо хотгор муруйн хамгийн бага радиус	м	769
11	Босоо хотгор муруйн хамгийн их радиус	м	4000
12	Дагуугийн хамгийн их налуу	%	3.1
13	Дагуугийн хамгийн их налууугийн үргэлжлэх урт	м	11.99
14	Замын далангийн өргөн	м	11.68, 9.520
15	Зорчих хэсгийн өргөн	м	6
16	Хөвөөний өргөн	м	0.5x2
17	Явган хүний замын өргөн	м	1.5x2
18	Тооцоот хурд	км/цаг	30
19	Өндөрлөгөөний хажуу налуу	m:n	1:1.5
20	Ухмалын хажуу налуу	m:n	1:1.5
21	Хучлагын хийц	-	Жижиг ширхэгтэй өнгө асфальтбетон – 3см Том ширхэгтэй суурь асфальтбетон – 4см Байгалийн чулуун хучилт – 10см Элсэн дэвсгэр үе – 5см Буталсан чулуун суурь – 20см Суурийн доод үе – 30см


2. ЗАМЫН ШИНЖ ЧАНАР

2.1. Зам, цаг уур амьсгал

Судалгааны талбай нь уур амьсгалын үзүүлэлтийг "Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл" (АЗУАГН 2.01.01-2004)-ийн дагуу тодорхойлов. Төлөвлөж буй авто замын зурвас Монгол орны авто замын уур амьсгалын мужлалаар IIB бүсэд орших бөгөөд авто замын уур амьсгалын хуурай хүйтэн сэрүүвтэр хахир, хуурайдуу сэрүүвтэр хүйтэн бэсрэг уулт хээр, хээр талын хахирлаг дэд бүс.

Тал хээрийн дэд бүс нь улирлын гүн хөлдөлттэй, овойлт болон суулт үүсгэнэ. Цас нимгэн, хахир өвөлтэй. Газар хөдлөлийн 6-7 балл.

Зам цаг уур амьсгалын үзүүлэлтүүдийг АЗУАГН 01.01.2004-с харна уу.



Зураг 5. Авто замын сүлжээ ба замын уур амьсгалын бүсчлэл

2.2. Авто замын байр зүйн судалгаа

Тус авто замуудын геодезийн нарийвчилсан хэмжилт, зураглал, боловсруулах ажлыг “Инженер геодези” ХХК нь шинээр баригдах авто замын зурагт зориулж төслийн талбайд 1:500 масштабтай байр зүйн зураглалын хэмжилтийн ажлыг 2021 оны 06 сарын 24-27 ны хооронд хээрийн хэмжилт, зураглалын ажлыг гүйцэтгэж, суурин боловсруулалтын ажлыг 2021 оны 07 сарын 01-27-нд хийж гүйцэтгэв.

Зураглалын ажлыг Монгол улсад мөрдөгдөж байгаа “1:10000, 1:5000, 1:2000, 1:1000, 1:500, 1:100-ны масштабтай байр зүйн дэвсгэр зургийн томъёолсон тэмдэг”, бусад бичиг баримтыг ашиглан гүйцэтгэв.



Зураг 6. Байрзүйн зураглал

Уг ажлыг гүйцэтгэхдээ дараах техникийн шаардлага, заавар, стандартыг үндэслэн гүйцэтгэсэн. Үүнд:

- Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан WGS-84 солбицол, UTM тусгагд зураглах
- Геодезийн байнгын цэг, тэмдэгт байгуулах ажил / БГД 11-104-19 / барилгын дүрэм
- “Геодезийн цэг, тэмдэгтийн хайгуул, судалгааны ажлын заавар”
- “Байр зүйн болон дэвсгэр тоон зураг, инженерийн дэд бүтцийн мэдээллийн санг хөтлөх” журам
- “1:5000, 1:2000, 1:1000, 1:500-ний масштабтай байр зүйн дэвсгэр зураглалын ажил” БД, 11-06-08 барилгын дүрэм
- “1:5000, 1:2000, 1:1000, 1:500-ний масштабтай зургийн томъёолсон тэмдэг” УГЗЗГ, 2001 он MNS6702:2017 стандарт
- “Геодезийн ажлын аюулгүй ажиллагааны техникийн дүрэм” УГЗЗГ, 1976 он
- “1:1000-ны масштабтай байр зүйн тодруулалт шинэчлэлт хийх ажлын зааварчилгаа”

Геодезийн байрлалын сүлжээг байгуулсан тухай

Геодезийн байрлалын сүлжээг хиймэл дагуул (GNSS)-ийн геодезийн харьцангуй аргаар солбицол тодорхойлох зарчмаар байгуулсан. Шинээр суулгасан цэгийн байрлалыг тодорхойлохдоо GP11 болон ГТЦ 5338 цэгт тулгуурлан бусад GNSS-ийн хүлээн авагчтай нэг агшинд 2 цагийн туршид хэмжин байрлалыг тодорхойлсон.

Сүлжээний хэмжилтийг БНХАУ-ийн Hi target фирмийн 2 долгионы irtk 5 маркын 4 иж бүрдэл багажаар хийж гүйцэтгэв.

1:500-ны масштабтай байр зүйн зураглалын ажил

Том масштабын байр зүйн зураглалын геодезийн үндэслэлийг “ Улсын геодезийн сүлжээ байгуулах техникийн нөхцөл” болон геодези, зураг зүйн үйлдвэрлэлийн ажилд мөрдөх бусад норм дүрэм, заавар, техникийн баримт бичгийн шаардлагын дагуу байгуулсан. Геодезийн сүлжээний цэгийн солбицол, өндрийг Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэглэж байгаа WGS84 систем UTM-49N тусгаг, Балтын тэнгисийн өндрийн системд хийж гүйцэтгэв. Төслийн байр зүйн зураглалын ажлыг 1:500-ны масштабтай 0.5 м үеийн өндөртэй, пикет хоорондын зайг 15метрээс ихгүй байхаар хийж гүйцэтгэв.

Агаарын зураглалын ажил

Агаарын зураглалын ажлыг DJI брэндийн M300 RTK дрон буюу нисгэгчгүй нисэгч төхөөрөмжүүдийг ашигласан. Суурин боловсруулалт болон 2D загварыг DJI TERRA болон Agisoft metashape программ хангамж дээр хийж гүйцэтгэсэн.



Зураг 7. Хэмжилт ажлын бэлтгэл үе

Дэлгэрэнгүй тайланг байр зүйн судалгааны тайлангаас үзнэ үү.

2.3. Авто замын инженер-геологийн судалгаа

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 7-р багийн нутагт Ургах наран, Боловсрол, Эко хотхоны доторх хатуу хучилттай авто замын зураг төсөв боловсруулахад зориулсан инженер-геологийн судалгааны ажлыг "Талын хөрс" ХХК 2021 онд 08 сард хийж гүйцэтгэв.

Гол төлөв боржин, диорит зэргээс бүрдэх ба эдгээр үндсэн чулуулгийг дөрөвдөгчийн настай, делюви-пролювийн гаралтай сэвсгэр хурдас газрын гадаргын хэлбэр дүрсээс хамаарч харилцан адилгүй зузаантай хучиж тогтжээ. Төлөвлөж буй

авто замын зурвасын дагуу хатуу консистенцтэй шавранцар ул хөрс, хайргархаг шавранцар ул хөрс илэрсэн бөгөөд 4.0 м гүн өрөмдлөгөөр сэвсгэр хурдасны зузаан нэвтрээгүй.

Судалгааны талбай геологийн тогтоцын хувьд 2 төрлийн ул хөрс илэрсэн, геоморфлогийн хэв шинжийн хувьд бэл хормойн гаралтай хуримтлалын хэв шинжит гадаргууд хамаарагдана. Гидрогеологийн нөхцлийн хувьд хөрсний ус илрээгүй зэргээс үзэхэд авто замын зурвас инженер геологийн энгийн нөхцөлтэй талбайд хамаарна.



Зураг 8. Өрөмдлөг хийж буй зураг

Дэлгэрэнгүй тайланг инженер -геологийн судалгааны тайлангаас үзнэ үү.

3. АВТО ЗАМЫН ТӨЛӨВЛӨЛТ

Уг авто зам нь Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 7-р баг "Боловсрол", "Ургах наран", "Эко" хорооллуудын дунд баригдах 3 хэсэг нийт 5.6км авто зам юм. Замын дэвсгэр зургийг М1:500 масштабтайгаар төлөвлөж, замын трасст аль болох объект орохгүй байх талаас нь төлөвлөв. Захиалагч байгууллагатай зөвшилцсөний үндсэн авто замын хөндлөн огтлолыг төлөвлөсөн бөгөөд шаардлагатай газруудад уулзвар, орц гарц, явган хүний гарц болон хурд сааруулагчийг төлөвлөсөн.

3.1. Төлөвлөлтийн стандарт шалгуур үзүүлэлт

а) Тус төслийн авто замууд нь Монгол улсад мөрдөгдөж байгаа БНБД 30-01-04 “ХОТ ТОСГОНЫ ТӨЛӨВЛӨЛТ БАРИЛГАЖИЛТЫН НОРМ БА ДҮРЭМ” –ийн 10-р

хүснэгтийн дагуу Нутаг дэвсгэрийн зам, нутаг дэвсгэрийн туслах гудамж, замд харъяалагдаж байна. Уг нормын дагуу авто замын геометр хэмжээсийг дараах байдлаар төлөвлөлөө.

Хүснэгт 14.


Үзүүлэлт	Төлөвлөсөн хэмжээ		
	1-р хэсэг. Боловсрол хорооллын авто зам – 2.062км	2-р хэсэг. Ургах наран хорооллын авто зам – 0.425км	3-р хэсэг. Эко хорооллын авто зам – 3.138км
Тооцоот хурд, км/ц	30	30	30
Замын нэг зурвасын өргөн, м	3.0	3.0	3.0
Замын эгнээний тоо	2.0	2.0	2.0
Ногоон байгууламж, м	1.0x2	-	0.5
Явган замын өргөн, м	1.5x2	1.5x2	1.5
Хөвөөний өргөн, м	0.5x2	0.5x2	0.5x2

Эх сурвалж: БНБД 30-01-04

3.2. Дагуу ба хөндлөн төлөвлөлт


Төлөвлөж буй авто зам, уулзваруудын дагуу болон хөндлөн огтлолыг ЗЗБНБД-004-2016, БНБД 30-01-04 норм стандартын дагуу төлөвлөлөө. Дагуу огтлолын зургийг босоо 1:100, хэвтээ 1:1000 масштабтай, хөндлөн огтлолыг 1:200 масштабтай төсөллөв.

1-р хэсэг. Боловсрол хорооллын авто зам




Зураг 9. Нэг маягийн хөндлөн огтлол төрөл-1

2-р хэсэг. Ургах наран хороолол авто зам



Зураг 10 Нэг маягийн хөвлөн огтлол төрөл-2

3-р хэсэг. Эко хороолол авто зам



Зураг 11. Нэг маягийн хөвлөн огтлол төрөл-3

3.3. Инженерийн шугам сүлжээ

Цэвэр, бохир усны шугам

Төлөвлөж буй авто замуудын хэмжилт болон газар дээр хийсэн хэмжилт судалгааны материал, газрын албаны мэдээллийн сангийн материал дээр үндэслэн “Ус сувгийн удирдах газар”-тай зөвшилцөн хийж гүйцэтгэлээ.

Нийт 64ш цэвэр, бохир усны шугамын худгийг авто замын төлөвлөлтийн түвшинд тохируулан ширмэн тагаар сольж хүзүүвч хийн одоо байгаа хоолойтой бэхэлж байрлуулна. шинэчлэхээр ажлын тоо хэмжээ болон зураг төсөвт тусгалаа.

Зураг төслийг “Ус хангамж, гадна сүлжээ ба байгууламж” БНБД 40-02-16, “Ариутгах татуурга, гадна сүлжээ ба байгууламж” БНБД 40-01-14, “Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм” БНБД заалтуудыг мөрдлөг болгон гүйцэтгэв. Шугам хоолой болон худаг өндөрлөж хүчитгэх угсралтын ажлыг гүйцэтгэхэд дараах шаардлагууд тавигдана.

Техникийн аюулгүй болон газар шорооны ажил гүйцэтгэх БНБД дүрмийг чанд мөрдөх. БНБД 40-04-16

Барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэхдээ “Ус хангамж, бохир ус гадна шугам сүлжээ, түүний барилга байгууламж” БНБД 30.05.04-90-ийг баримтлан хийнэ үү.

- Газар шорооны ажил эхлэхийн өмнө холбогдох газруудаас зөвшөөрөл авч цахилгааны болон бусад шугам сүлжээтэй огтлолцосон хэсгийг тэмдэглүүлж гараар ухах.
- Шугам хоолойг булахаас өмнө холбогдох төлөөлөлийг байлцуулж битүүмжлэлийг нь шалган ил далд ажлын акт хөтлөх.
- Угсралтын ажлыг хийж гүйцэтгэхэд хөндөгдөх зам талбайг ажлын гүйцэтгэл дууссаны дараа буцааж булах хөрсийг сайтар нягтруулж гудамж талбайн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэнэ.
- Шугам хоолойг технологийн болон ажлын зураг төслийн дагуу хийж гүйцэтгэх

Дулаан шугам

Төлөвлөж буй замуудад “**ДӨРВӨЛ ОНӨГ**” ХХК-тай зөвшөлцөн 25ш дулааны худаг өндөрлөх, 4ш дулааны худаг шинээр хийх, 900м дулааны шугам хүчитгэхээр зураг төсөлд тусгаж өгөв.

Цахилгаан, гэрэлтүүлгийн шугам

Төлөвлөж буй замуудын цахилгааны шугамыг шинэчлэх, зөөх, гэрэлтүүлгийн ажлын зураг төслийг “ЧАНДМАНЬ ХОНГОР ГРУПП” ХХК боловсруулсан бөгөөд дэлгэрэнгүй ажлын зураг төслөөс үзэх.

Холбооны шугам

Төлөвлөж буй замуудын холбооны шугамыг шинэчлэх, зөөх ажлын зураг төслийг “АРБЭЛ-АЛТАЙ” ХХК боловсруулсан бөгөөд дэлгэрэнгүй ажлын зураг төслөөс үзэх.

3.4. Хучилтын хийц, тооцоо

Төслийн авто замууд нь зургийн даалгаврын дагуу асфальтбетон хучлагатай байхаар төлөвлөлөө.

- Хучилтын тооцооны аргачлал

Хучилтын тооцооны онолын олон аргачлалууд байдаг ба дараах аргуудыг түгээмэл ашигладаг. Үүнд:

Хучилт
1) ТА арга
2) ААШТО аргачлал
3) CBR арга
4) Шэлл –ийн арга
5) Механик –Эмпирик арга

Дээрх аргуудаас AASHTO INTERIM GUIDE METHOD нь онол болон практикийн үндэслэл ихтэй хучилтын тооцоог хийхэд энгийн хялбар, түгээмэл хэрэглэж ирсэн.

AASHTO аргаар хучилтын бүтээц төлөвлөхөд дараах өгөгдлүүдийг авч үздэг.

Үүнд:

1. pavement performance
2. Хөдөлгөөний эрчим /traffic/
3. Найдваржилтын түвшин /reliability/
4. Хүрээлэн буй орчин, уур амьсгал /Environment/
5. Материал /materials/
6. Үйлчилгээний түвшин /Serviceability/
7. Drainage

8. Суурийн доод үеийн материалууд Subgrade material

Хучилтын зузааны тооцоо

Хэтийн хөдөлгөөний эрчим болон нэг тэнхлэг дээрх ачааллын тооцоо

Хучилтын хийцийг дараах байдлаар сонгон тооцоог хийлээ. Үүнд:

Асфальтбетон	7см	57см
Буталсан чулуун суурь	20см	
Суурийн доод үе	30см	

Зураг 12. Хучилтын хийц

1) Агуулга

Тус төслийн замын техникийн шаардлагад асфальтбетон хучилтын давхрагыг 3см, 4см-т хувааж нийт 7см-т тооцоолж суурийг 20см, дэд суурийг 30см-ээр тооцоолон хучилтын тэсвэрлэх чадварыг хөдөлгөөний эрчим хамгийн их байхаар төлөвлөсөн.

ААШТО тооцооллоор хөдөлгөөний нэвтрүүлэх чадварыг судалж, нэг урсгал дээрх хөдөлгөөний нэвтрүүлэлтийг жил тус бүрийн хөдөлгөөний нэвтрүүлэх чавдартай харьцуулан тооцоолж тээврийн хэрэгслийн өсөлтийг ойролцоогоор тооцоолон урт хугацааны хөдөлгөөн нэвтрүүлэх чадварыг төлөвлөн хучилтын зузааныг тооцож, тус төслийн техникийн шаардлагад нийцүүлэн хамгийн их хөдөлгөөн нэвтрүүлэлтэнд тэсвэрлэлт сайтайгаар төлөвлөв. Хучилтын тооцоот ашиглалтын хэтийн жилийг 20 жил байхаар тооцлоо.

Энэхүү аргачлалд өөр өөр тэнхлэгийн ачаалалтай холимог хөдөлгөөний эрчмийг 18 кип буюу 80кН нэг тэнхлэгийн ачаалалд шилжүүлж тооцно. Нэг тэнхлэг дээр ачааллыг ESAL –аар илэрхийлнэ. ESAL- Equivalent single axle load (Нэг тэнхлэг дээрх ачаалал)

18кип≈80кН≈18000поунд≈8164.6кг≈8.2 тн (Нэг тэнхлэг дээрх ачаалал)

2) Барилгын ажлын хугацаа, ашиглалтанд өгөх жил, хэтийн жил
Хүснэгт. 15

Ангилал	Барилгын ажлын хугацаа (үндсэн шугам ашиглалтанд орох)	Ашиглалтанд өгөх жил	Хэтийн жил (20 жилийн дараа)
Жил	1	2022	2042

3) Хөдөлгөөний эрчим

- Тооцоот ашиглалтын хугацааны туршид үйлчлэх хөдөлгөөний нийт эрчмийн тооцоог дараах байдлаар тооцоолсон.

$$\omega_{18} = D_D \times D_L \times \omega_{18}^1$$

Үүнд :

ω_{18} - хөдөлгөөний эрчим

D_D - хөдөлгөөний чиглэлийн тархалтыг тооцсон коэффициент, энэ нь замын эсрэг

урсгалуудад хөдөлгөөний ачааллын тархалтыг тооцсон коэффициент,
Distribution coefficient by direction ($D_D = 0.5$)

D_L - зорчих хэсгийн нэг зурваст хөдөлгөөний тархалтыг илэрхийлсэн коэффициент

Distribution coefficient ($D_L = 1.0$)

ω_{18}^1 - хучилтын ашиглалтын тооцоот хугацаанд зорчих хэсгийн хоёр урсгалд үйлчлэх

стандарт тэнхлэг давтагдах нийт тоо

Нэг урсгал дээрх хөдөлгөөний эрчмийн жил тус бүрийг дараах байдлаар төлөвлөсөн ба хэтийн 20 жилийн хөдөлгөөний эрчмийг хучилтын зузааны тооцоонд авлаа.



Хэтийн хөдөлгөөний эрчмийн таамаг (AADT)

Хүснэгт.16

Жил	Суудлын авто машин	Автобус		Ачааны машин			Бүгд	Тайлбар
		Бага оврын	Том оврын	Бага оврын	Дунд оврын	Том оврын		
2022	2186	28	66	423	172	261	3136	Ашиглалтанд өгөх
2031	3693	37	86	552	224	341	4933	Ашиглалтанд өгсөнөөс хойш 10 жил
2036	4942	42	100	640	260	395	6379	Ашиглалтанд өгсөнөөс хойш 15 жил
2041	6614	49	116	742	302	458	8280	Ашиглалтанд өгсөнөөс хойш 20 жил

Хөдөлгөөний эрчмийн өсөлт (томсгосон үзүүлэлт)

Хүснэгт.17

Жил	Суудлын автомашин	Автобус		Ачааны авто машин		
		Бага оврын	Том оврын	Бага оврын	Дунд оврын	Том оврын
2022 ~2026	143	1	2	13	5	8
2026 ~2031	187	1	2	15	6	9
2031 ~2036	250	1	3	18	7	11
2036 ~2041	334	1	3	20	8	13


Нэг тэнхлэг дээрх ачааллыг шилжүүлсэн хөдөлгөөний эрчим (18Kips)

Хүснэгт.18

Жил	Суудлын авто машин	Автобус		Ачааны машин			Нийт	Жилд нэг тэнхлэг дээр ирэх хөдөлгөөний эрчим __X10 ⁶	Жилд нэмэгдсэн байдлаар нэг тэнхлэг дээр ирэх хөдөлгөөний эрчим, ω ₁₈ ¹ __X10 ⁶	Тооцоот хугацаан дахь хөдөлгөөний эрчим, ω ₁₈ __X10 ⁶	Тайлбар
		Бага оврын	Ердийн	Бага оврын	Дунд оврын	Том оврын					
2022	0.44	0.03	56.03	1.69	105.26	534.53	697.98	0.2548	0.2548	0.1147	Ашиглалтанд өгөх
2031	0.74	0.04	73.11	2.21	137.35	697.44	910.88	0.3325	2.9210	1.3145	Ашиглалтанд өгсөнөөс хойш 10 жил
2036	0.99	0.04	84.76	2.56	159.22	808.52	1056.09	0.3855	4.7392	2.1326	Ашиглалтанд өгсөнөөс хойш 15 жил
2041	1.32	0.05	98.26	2.97	184.58	937.30	1224.47	0.4469	6.8473	3.0813	Ашиглалтанд өгсөнөөс хойш 20 жил

4) CBR болон хучилтын үеүдийн коэффициент

Төлөвлөж буй трассын дагуух ул хөрсний CBR үзүүлэлтүүд



Хучилтын тооцооны стандарт

Далангийн дээд үе, ул хөрс: CBR > 20%

Дэд суурийн үе: CBR > 30%

- Хөрсний үзүүлэлт (Soil Support Value)

Хөрсний утга нь CBR утгаас хамаарна.

Хүснэгт 19.

Ангилал	Тооцоот CBR, %	Хөрсний үзүүлэлт (SSV)	Тайлбар (Бодолт)
Далангийн дээд үе, ул хөрс	20.0	6.2	$3.8 \times \text{Log}20.0 + 1.3 =$
Дэд суурь	30.0	6.9	$3.8 \times \text{Log}30.0 + 1.3 =$

- Хучилтын *i* дугаар үеийн коэффициент / a_i /

Хүснэгт 20.

Хучилтын үе / Ангилал	Асфальт бетон үе	Суурийн үе		Дэд суурийн үе	Тайлбар
		Асфальтын ачааллыг хүлээн авах хязгаар	Цементээр бэхжүүлсэн суурь		
Техникийн шаардлагад заасан бат бэхийн чанар	нягтрал $\varnothing 19\text{mm}$ ачааллыг хүлээн авах	Ачааллыг хүлээн авах хязгаар 350кг дээш	C.B.R 80%-с дээш	C.B.R 30%-с дээш	

	хязгаар 750кг дээш				
Бат бэхийн коэффициент	0.145	0.110	0.051	0.043	

5) Зураг төслийн үндсэн тэгшитгэл (ААШТО)

$$\log_{10}(W_{18}) = 9.36 \times \log_{10}(SN + 1) - 0.2 + \frac{G_t}{0.4 + \frac{1094}{(SN + 1)^{5.19}}} + \log_{10}\left(\frac{1}{R_f}\right) + 0.372(SSV$$

– 3.0)

W_{18} -8.2тн буюу нэг тэнхлэг дээр ирэх ачааллын хөдөлгөөний эрчим

SN -Бүтээцийн утга (Structural Number)

R_f -Бүсийн индекс (өндөр 500м –ээс дээш бүсэд : 2.5)

P_f -Эцсийн зураг төслийн индекс (2.5)

$$G_t = \log \frac{4.2 - P_t}{4.2 - 1.5}$$

6) Хучилтын зузааны тооцоо (шаардагдах SN)

Хүснэгт 21.

Тооцооны утгууд				
Хөдөлгөөний эрчим ($W_{8.2}$)	1 314 500	C B R		Хөрсний үзүүлэлт (SSV)
Үйлчилгээний түвшин (P_t)	2,0	Дэд суурь	30%	6,9
Бүсийн индекс (R_f)	2,5	Далангийн дээд үе, ул хөрс	20%	6,2
Хучилтын зузааны тооцоо (шаардагдах SN)				
Суурь (SN_2)	3,664		Дэд суурь (SN_3)	5,077
$\log(W_{8.2})$	6,99664		$\log(W_{8.2})$	7,747
Шалгалт: O.K		Шалгалт: O.K		

Үндсэн илэрхийлэл томъёо

- $\log(W_{8.2}) = 9.36 \times \log(SN+1) - 0.2 + (G_t/(0.4+1094/(SN+1)^{5.19})) + \log(1/R_f) + +0.372(SSV-3.0)$

$$SSV = 3.8 \log CBR + 1.3$$

$$G_t = \log(4.2 - P_t) / (4.2 - 1.5)$$

7) Хучилтын зузааны тооцоо (тооцоот SN)

Бат бэхийн коэффициент (Layer Relative Strength Factor)

- асфальтбетон: 0.157
- асфальтбетон: 0.11
- суурийн үе: 0.051
- дэд суурийн үе: 0.043

Хүснэгт 22.

Хучилтын үе	Хучилтын i дугаар үеийн коэффициент T	Үеийн зузаан (см)	Тооцоолол	Тооцоот SN	Хэрэгцээт SN	Шалгалт
Өнгөн АБ	0.157	3	$3 \times 0.157 =$ 0.471	0.471		
Суурь АБ	0.11	4	$4 \times 0.110 =$ 0.440	$0.44 + 0.43$ $5 =$ 0.875		
Суурийн үе	0.051	20	$20 \times 0.051 =$ 1.02	$0.875 + 1.102 =$ 1.895	$SN_2 = 1.5$ 81	Хэрэгцээт \leq Тооцоот $1.581 < 1.895$ Шалгалт ОК
Дэд суурийн үе	0.043	30	$30 \times 0.043 =$ 1.29	$1.29 + 1.995 =$ 3.285	$SN_2 = 1.7$ 55	Хэрэгцээт \leq Тооцоот $1.755 < 3.285$ Шалгалт ОК
Нийт		57				

Дээрх тооцооноос үзэхэд хучилтын хийцийн сонголт нь шаардлага хангаж байна.


3.5. Ус зайлуулах байгууламж

Төлөвлөж нийт байршилд тус бүрд гадаргуун ус зайлуулах байгууламжийг шийдэн төлөвлөж өгсөн. Зам дээрх гадаргын усыг 2 талруугаа зайлуулахаар төлөвлөсөн. Ус зайлуулах U хэлбэрийн бүтээц нь 500х300х210 харьцаатай байх бөгөөд бүтээцийг худалдаж авахаар төлөвлөв. Мөн U хэлбэрийн бүтээцэд нүхтэй бетон таг байрлуулахаар хийлээ. Дэлгэрэнгүйг нарийвчилсан зургаас үзнэ үү.

Үүнд:


1. Ургах наран хорооллын доторх авто замуудын гадаргын усыг U хэлбэрийн Лоткигоор авто замын 2-р тал руу зайлуулхаар төлөвлөж өгсөн. (Доорх зургаас үзэх)
2. Эко болон Боловсрол хорооллын доторх авто замуудын гадаргын усыг U хэлбэрийн Лоткигоор авто замын 2-р тал руу зайлуулхаар төлөвлөж өгсөн. Мөн 4-н байршилд буюу 1. Боловсрол хороолол 1-р зам Пк 0+028.99; 2. Боловсрол хороолол 2-р зам Пк 0+012.60; 3. Эко хороолол 7.2-р зам Пк 0+206.321; 4. Эко хороолол 8.2-р зам Пк 0+206.411; хэсэгт ус зайлуулах хоёр хос ган хоолой /D=500мм/ болон ус залах бэхэлгээтэй бетон шуудуутай байхаар тус тус төлөвлөж өгөв.

(доорх зургаас үзэх)




Зураг 13. Гадаргын ус зайлуулах лотки ерөнхий харагдах байдал.

Зураг 14. Гадаргын ус зайлуулах лотки дээрээс харагдах байдал




Зураг 15. Гадаргын ус зайлуулах лотки нүүрэн талаас харагдах байдал.

Хийцны хэмжээс




Зураг 16 Гадаргын ус зайлуулах лоткины зай хэмжээ

Нэг маягийн хөндлөн огтлол



Зураг 17. Бетон шуудуу



Зураг 18. Ус зайлуулах 2-р хос ган хоолой / D=500мм /

3.6. Ус зайлуулах U хэлбэрийн байгууламж /Лотки/ техникийн шаардлага:

Хот суурин газрын гудамж замын гадаргуугийн ус зайлуулах төмөрбетон “U” сувгийг энэ стандарт болон мөн зохих журмаар батлагдсан технологийн заавар, ажлын зургийг баримтлан хийж гүйцэтгэнэ.

Төмөрбетон “U” сувгийн бетон бүтээцүүдийг үйлдвэрлэхэд хэрэглэх материалууд нь дараах стандартын шаардлагыг тус тус хангасан байна.

Үүнд:

- Бетонд хэрэглэх дүүргэгч материал нь MNS 2803: 2004,
- Арматурын ган туйван MNS JIS G 3112: 2002; СТО АСТЧМ7-93;
- Ган утас нь ГОСТ 5781-93; ГОСТ 6727-80*.

Төмөрбетон “U” сувгийн бүтээцүүдийг В25 болон түүнээс дээш ангиллын бетоноор хийнэ. Гадна гадаргын барзайлт бүх гадаргын талбайн 5%-иас хэтрээгүй байна. Төмөрбетон “U” сувгийн бетон бүтээцүүдийн геометр хэмжээсийн хүлцэх зөрүү нь доор зааснаас хэтрэхгүй байна.

Үүнд:

- “U” сувгийн уртад ± 5 мм;
- “U” сувгийн хөндлөнд ± 5 мм;
- “U” сувгийн ханын зузаанд ± 3 мм;

“U” сувгийн бетон бүтээцүүдийн арматурын бетонон хамгаалалтын үеийн зузаан 15 мм-ээс багагүй байна.

“U” сувгийн бетоны шахалтын бат бөх (зураг төсөлд өөрөөр заагаагүй бол) 35МПа-аас багагүй байна.

“U” сувгийн бетоны хүйтэн тэсвэрлэлтийг 5%-ийн натрийн хлорын уусмал ашиглан туршиж тодорхойлох бөгөөд шахалтын бат бөх нь 5%, жингийн алдагдал нь 3%-иас тус тус ихгүй байна.

“U” сувгийн бетон эдлэлийн арматур, бэхэлгээний эд ангийн дүрс, хэлбэр, хэмжээ болон байрлал нь энэхүү стандартын зурагт үзүүлсэнтэй тохирч байх шаардлагатай. Ширээсэн арматурын хэлхээс, бэхэлгээний эд анги нь MNS 2797-2001, MNS 3073-2001 стандартын шаардлагыг хангасан байна.

Бүтээцийн угсралтын гох, дэгээг халуунаар цувисан зохих ангиллын цулгүй бөөрөнхий шилбээр хийнэ. Уян харимхай чанар бүхий зохих ангиллын ганг гадна агаарын температур (-40°C)-ээс бага байх нөхцөлд эдлэхүүний гох, дэгээнд хэрэглэхийг хориглоно.

Арматурын гаргалгаа, бэхэлгээний эд ангийн төрөл, байрлал, теникийн шинж

чанар нь эдлэхүүний зурагт заасантай тохирч байвал зохино.

“U” сувгийн бетон бүтээцийг ачааллаар шалгахад энэ стандарт болон зураг төсөлд заасан бат бөхийн шаардлагыг хангасан байна.

“U” сувгийн бетон бүтээцийн гадаргуугийн бетон үе ховхорч унасан, нүх сүв, эмтрэл гараагүй байна.

“U” сувгийн бетон бүтээцийг газар дээр нь цутгах, арчлах ажлыг энэхүү ТШ-ын бүлэг 1200-ын заалтуудыг баримтлан гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч нь “U” сувгийн бетон бүтээцийн ажлыг хэрхэн хийх аргачлалаа энэхүү ТШ -д заасны дагуу боловсруулж, барилгын ажил эхлэхээс өмнө ТИ-ээр батлуулан мөрдөнө.

Бэлэн болсон арматурын сараалжыг хяналтын инженер шалгаж зөвшөөрсөний дараа “U” сувгийн бетон бүтээцийн хэв хашмалыг ажлын зургийн дагуу угсарч, мөн хяналтын инженерт шалгуулан зөвшөөрөл авна. Хэв хашмалыг төсөллөх, барих, ажилд бэлтгэх, буулгахдаа ТШ- д тусгасныг мөрдөнө.


Зорчих хэсгийн ирмэгээс “U” сувгийн бетон бүтээцрүү гадаргуун усыг зайлуулахын тулд хүлээн авж буй хэсэгт хөндлөн хэвгийг 3%-н налуутай хийж өгнө.

Зорчих хэсгийн гадаргуун усыг “U” сувгийн бетон бүтээцээр зайлуулах хэсэгт хийгдэх явган замын хөндлөн хэвгий болон түвшинг уялдуулж хийнэ.

Дэлгэрэнгүйг “ТЕХНИКИЙН ШААРДЛАГА”-аас үзнэ үү.

3.7. Явган хүний замын хийц

Явган хүний замаар зорчигч нь энгийн зорчигчид байхаас гадна хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настан, хүүхдүүд, тэрэг түрсэн иргэд байна. Тиймээс явган хүний замыг аль болох бүгдэд хүртээмжтэй, саадгүй байх талаас бодолцон барилгын




ажлыг хийнэ.

Зураг 19. Нэг маягийн хөндлөн огтлол

Явган хүний замыг 6см-н зузаантай 10см х 20см харьцаатай /В-22.5/ хүрэн, улаан хүрэн, цайвар шар өнгийн өнгөт хавтангуудаар өрж хийнэ. Өрөлтийг зураг төсөлд заасны дагуу зөвлөх болон захиалагчтай зөвшилцөн өрж өгнө.


Харааны бэрхшээлтэй иргэдийн хөтөч хавтан: Харааны бэрхшээлтэй хүнд зориулсан хавтан нь чиглүүлэгч болон анхааруулах гэсэн 2 төрөл байна. Хөтөч хавтан гэж харааны бэрхшээлтэй иргэд явган хүний замаар зорчихдоо таягаар дамжуулан хүрэлцэх мэдрэхүйгээрээ мэдэрч чиглэлээ баримжаалан явах зориулалттай товгор хээтэй хавтанг нэрлэх ба анхааруулах хавтан, чиглүүлэгч хавтан гэсэн төрлүүд байдаг.

Анхааруулах хавтан: Анхааруулах хавтанг гарц, явган зорчигчийн хүлээж зогсох цэг, очих цэгт таарах салаа замыг зааж өгөх болон замд таарах саадыг мэдээлж чиглүүлэгч хавтан руу шилжих, уулзвар, муруй хэсэгт суурьлуулан чиглэл өөрчлөгдөхийг анхааруулахад ашиглана. Явган хүний гарцан дээр анхааруулах хавтанг хийж өгнө.




Зураг 20. Анхааруулах хавтангийн стандарт хэмжээ

